

**ХЭНТИЙ АЙМГИЙН УЦУОШТ-ийн ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧИЙН
АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ**

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтын боловсруулсан үндэслэл:

- Байгууллагын бүтэц, орон тоо шинэчлэгдсэн.
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон.

**Холбогдох хууль тогтоомжийн нэр,
огноо:**

“Аймаг, хотын ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дүрэм, бүтэц орон тооны хязгаарыг батлах тухай” ЦУОШГ-ын А/162 дугаар тушаал

Дагаж мөрдөх огноо:

2025. 09. 01

**Албан тушаалын тодорхойлолтыг баталсан
огноо:**

2025. 08. 13

Байгууллагын нэр:

Хэнтий аймгийн Ус, цаг уур, орчны
шинжилгээний төв

Нэгжийн нэр:

Захиргаа аж ахуйн хэлтэс

Албан тушаалын нэр:

Ерөнхий нягтлан бодогч

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Төрийн үйлчилгээний мэргэжил
ангилал, ТҮМ-7

Ажлын цаг:

Ажлын 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Хэнтий аймгийн Хэрлэн сумын 2-р баг
Тэмүүжингийн гудамж Н-13

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ**Албан тушаалын зорилго:**

Байгууллагын санхүү бүртгэлийн ажлыг нягтлан бодох бүртгэлийн хууль, Төсвийн тухай хууль болон бусад хуульд нийцүүлэн Монгол улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу хөтөлж, удирдлагыг санхүүгийн үнэн зөв бодит мэдээ, мэдээллээр хангах.

Албан тушаалын зорилт

1. Байгууллагын үйл ажиллагааны төсвийг үнэн зөв зохиох, төслийг батлуулах, батлагдсан төсвийн хуваарийн дагуу санхүүжилт авч төсвийн гүйцэтгэлийн мжджжг сар бүр гарган цаг хугацаанд нь өгөх, нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу санхүүгийн тайлангуудыг цаг хугацаанд нь хүргүүлэх, удирдлагыг санхүүгийн үйл ажиллагааны талаар үнэн зөв бодит мэдээллээр хангах.
2. Холбогдох хууль, тогтоол, захирамж, дүрэм, журмыг дагаж мөрдөх.
3. Бусад нийтлэг чиг үүргийн дагуух ажлуудыг хийж гүйцэтгэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах-Т Хариуцан гүйцэтгэх-Г Хянах-Х Шийдвэрлэх - Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	<ul style="list-style-type: none">• Байгууллагын төсвийг холбогдох хууль, дүрэм журам, зааврын дагуу үнэн зөв хийж батлуулах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зөв зарцуулах.• Санхүүгийн үйл ажиллагааг Аймгийн төрийн аудитын газар болон бусад холбогдох чиглэлийн байгууллагуудад шалгуулж, холбогдох мэдээлэл анхан шатны баримтуудыг гарган өгч хамтран ажиллах, шалгалтуудаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах.• Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах үүргийн дагуу санхүүтэй холбоотой. Тушаалууд, харилцах дансанд орсон орлого, зарлагын гүйлгээ болон бусад холбогдох мэдээллүүдийг үнэн зөв цаг хугацаанд нь оруулсан эсэхэд хяналт тавьж, хариуцсан ажилтнуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллах.• Харилцах дансны орлого	70%	Г,Х

	<p>зарлагын гүйлгээ тухай бүрд шалгах, санхүүгийн анхан шатны баримтуудыг үндэслэн санхүүгийн программд орлого болон зарлагын гүйлгээнүүдийг шивж санхүүгийн тайлан мэдээг цаг хугацаанд нь гаргах, харилцагч байгууллагуудтай өр, авлага үүсгэхгүй ажиллах.</p> <ul style="list-style-type: none"> • Албан хаагчдын цалин хөлсний тооцоог гарган сар бүрийн хуваарьт өдөр олгох, нийгмийн даатгалын шимтгэл, хүн амын орлогын албан татварыг цаг тухайд нь шилжүүлж холбогдох тооцоог хийж, өр авлагагүй ажиллах. • Сар улирал бүр гаргадаг мэдээ тайланг үнэн зөв хуулийн дагуу хугацаанд нь гаргаж холбогдох газруудад хүргэсэн байх. • Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны талаар төвийн даргад үнэн зөв бодит мэдээлэл өгч, байгууллагын харилцах данс, бэлэн мөнгөний баримтад 2-р гарын үсэг зурах. • Байгууллагын үндсэн хөрөнгө болон эргэлтийн хөрөнгийг хагас, бүтэн жилээр тоолж тооллогын дүнг Өмч хамгаалах байнгын зөвлөлд танилцуулах, Аймгийн өмчийн харилцааны газартай өмч хөрөнгөтэй холбоотой асуудлыг хариуцан, хяналт тавих. 		
2 дугаар зорилтын хүрээнд	<ul style="list-style-type: none"> • Эрхэлсэн ажлын хүрээнд Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Шилэн дансны тухай, Төрийн албаны тухай, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоол, захирамж, дүрэм, журмыг мөрдөж ажиллах. 	10%	Г
3 дугаар зорилтын хүрээнд	<ul style="list-style-type: none"> • Дээд шатны байгууллагын тогтоол шийдвэр, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь биелүүлж, ажлын гүйцэтгэл, үр дүнг тогтмол тайлагнах. 	20%	Г,Ш,Х

	<ul style="list-style-type: none"> • Байгууллагын хөтлөх хэргийн жагсаалтын дагуу архивын баримтыг хариуцсан албан хаагчид цаг хугацаанд нь өгөхөд хяналт тавих. • Эрхэлсэн ажил үүргийн хуваарийн дагуу бүтэн жилээр төлөвлөгөө гаргах, сар бүр биелэлтийг хангаж хариуцсан ажлаа цаг хугацаанд нь чанартай гүйцэтгэх. • Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан өөрийн хариуцсан ажлыг цаг хугацаанд нь хийж гүйцэтгэх. 		
--	--	--	--

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Дээд боловсролын бакалавр болон түүнээс дээш
Мэргэжил	Эдийн засагч, нягтлан бодогч
Мэргэшил	Мэргэшсэн нягтлан бодогч
Туршлага	Мэргэжлээрээ 2-оос доошгүй жил ажилласан.
Ур чадвар	<ul style="list-style-type: none"> • Компьютерийн өргөн хэрэглээний програмууд дээр ажиллах чадвартай болон шинээр нэвтэрсэн програмуудыг хурдан хугацаанд бүрэн ашиглаж сурдаг байх. • Ёс суртахууны доголдолгүй, харилцааны соёлтой, хувийн зохион байгуулалт сайтай, хариуцлага хүлээх, шийдвэр гаргах чадвартай байх. • Албаны болон хувийн нууц хадгалах, багаар ажиллах, мэргэжлийн түвшинд асуудал боловсруулах, үнэлэлт, дүгнэлт өгөх, ачаалал даах чадвартай байх. • Албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу баримт боловсруулах чадвартай байх. • Монгол бичгээр унших, бичих зохих түвшний мэдлэгтэй байх.


IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

1. Ус цаг уур орчны шинжилгээний төвийн дарга

--	--

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ	
Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
Албан тушаал: <i>Дуний нөөцийн ажигтан</i> <i>С. Байсгалан</i> (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 2025 оны 08 дугаар сарын 13-ны өдөр	Байгууллагын нэр: <i>УУ УО М Төв</i> Шийдвэрийн огноо: <i>2025.08.13</i> Дугаар: <i>Б/44</i>

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:	
Байгууллагын нэр: <i>УУ УО М Төв</i>	
Шийдвэрийн огноо: <i>2025.08.13</i>	
Дугаар: <i>Б/44</i>	
(тамга/тэмдэг)  (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 2025 оны 08 дугаар сарын 13 өдөр	
Танилцсан.....	